

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ОТГОНСҮХ



## МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

CKD4B серийн зүтгүүрт засвар, үйлчилгээ хийж гүйцэтгэх  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

MTZ/202401116

2024 он

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

#### 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

#### 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

#### 4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

#### 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

#### 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

**7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## **Б.АГУУЛГА**

### **8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

### **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

## **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

## **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

## **В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

### **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийн баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;
- 13.2.8. ТШЗ-ны 21.6-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

### **14. Тендерийн жишиг маягтууд**

### **15. Хувилбарт санал**

### **16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендert ирүүлнэ.

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

## **17. Чадавхын болон туршлагын шаардлага**

## **18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

	талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт</b>	<p>19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.</p>
<b>20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг</b>	<p>20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.</p> <p>20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.</p>
<b>21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт</b>	<p>21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.</p> <p>21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>21.3.ТШЗ-ны <b>Error! Reference source not found.</b>-т з аасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.</p> <p>21.4.ТШЗ <b>Error! Reference source not found.</b>-т заасны д агуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.</p> <p>21.5.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.</p>

21.6.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

## **22. Тендерийн валют**

22.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

## **23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2.Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

## **24. Тендерийн баталгаа**

24.1.Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2.Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3.Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4.Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**

### **25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1.Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

**27. Тендерийн талаар тодруулга авах**

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

**Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**29. Тендерийг үнэлэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

**30. Арифметик алдааг залруулах**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

**31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

**32. Тендерийн харьцуулах**

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход

## **үнийг тодорхойлох**

дараах дарааллыг баримтална:

- 32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
  - 32.1.2. ТШЗ-ны 21.4-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
  - 32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
  - 32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
  - 32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоходоо дараах аргачлалыг баримтална:
    - 32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
    - 32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлоходоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
    - 32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
  - 32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
  - 32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

## **33. Тендерийг эрэмбэлэх**

- 33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

## **34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

- 34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай

эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

- 34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

### Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- |  |  |
|--|--|
| 35. Мэдэгдэл хүргүүлэх                     | 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.   |
| 36. Гүйцэтгэлийн баталгаа                  | 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.<br>36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.  |
| 37. Урьдчилгаа төлбөр                      | 37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.  |
| 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах | 38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.<br>38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.<br>38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.<br>38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно. |
| 39. Тендер шалгаруулалтын гомдол           | 39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.  |

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: “Монголын төмөр зам” ТӨХК
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>CKD4B серийн зүтгүүрт, засвар, үйлчилгээ хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: <b>МТЗ/202401116</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “ <b>Багцгүй</b> ”
<b>ТШЗ 1.3</b>	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: “ <b>Өөрийн хөрөнгө</b> ”
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>9,879,104,000</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 9.1</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: <b>Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 дугаар хороолол, Нарны зам-62, Юнион бюлдинг, Б блок, 7 давхар.</b> Хүлээн авагчийн нэр: <b>Худалдан авалтын мэргэжилтэн Б.Ундрах</b> Утасны дугаар: <b>70006464</b> Цахим шуудангийн хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>
<b>ТШЗ 10.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ <b>Үгүй</b> ”
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.1</b>	Тендер шалгаруулалтын хэл: “ <b>Монгол хэл</b> ” Тендер шалгаруулалтын урилга, тендерийн баримт бичгийг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: “ <b>Зөвшөөрөхгүй</b> ”
<b>ТШЗ 16.1.2</b>	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай бусад баримт бичиг: “ <b>Шаардахгүй</b> ”
<b>ТШЗ 18.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлага: “ <b>Шаардана</b> ”

	Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 оны борлуулалтын орлогын дундаж нь батлагдсан төсөвт өртгийн 90 хувиас багагүй байх.
<b>ТШЗ 18.2</b>	Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: Үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацаа: Сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг ирүүлэх.
<b>ТШЗ 19.1</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “<b>Шаардана</b>”</p> <p>Уг үйлчилгээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэх ажилтан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Удирдах ажилтан нь дээд боловсролтой, тухайн салбарт мэргэжлээрээ 20-оос дээш жил ажилласан байх.</li> <li>- Хяналт тавих мэргэжилтэн нь дээд боловсролтой, тухайн салбарт мэргэжлээрээ 15-аас дээш жил ажилласан байх.</li> <li>- Үйлчилгээ үзүүлэх дизель хөдөлгүүрийн засварчин-2, Цахилгаан моторын засварчин-1, Цахилгаан, электроникийн засварчин-1, Механикийн засварчин-1, Хийн тоормосны системийн засварчин-2 тус бүр тухайн салбарт мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх.</li> </ul> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “<b>Шаардана</b>”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дизель хөдөлгүүрийн засвар үйлчилгээний үндсэн тоног төхөөрөмж, туршилтын тоног төхөөрөмж,</li> <li>- Моторын засвар үйлчилгээний үндсэн төхөөрөмжүүд,</li> <li>- Цахилгаан, электрон, хэмжилтийн хэрэгслийн засвар үйлчилгээний үндсэн төхөөрөмж,</li> <li>- Механик засварын тоног төхөөрөмж</li> <li>- Хийн тоормосны системийн засвар үйлчилгээний тоног төхөөрөмж,</li> <li>- Согог ирүүлэх, шалгах төхөөрөмж</li> <li>- Цэвэрлэгээний тоног төхөөрөмж г.м бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүд зайлшгүй байна. Үүнийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх.</li> </ul> <p>Засварын талбай хэмжээ тухайн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэхэд шаардагдах байр, талбай түүний талаарх нотлох баримт, танилцуулгыг ирүүлэх.</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “<b>Шаардана</b>”</p> <p>Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудад ижил төстэй зүтгүүрийн их, дунд засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн гэрээний мэдээллийг маягт 2-ын дагуу бэлтгэн ирүүлэх. Уг хугацаанд ижил төстэй үйлчилгээг жил бүр 1-с доошгүй удаа гүйцэтгэсэн байх ба нийт гэрээний дундаж өртөг нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 90 хувиас багагүй байна.</p>

	<p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “<b>Шаардахгүй</b>”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “<b>Шаардахгүй</b>”</p>
<b>ТШЗ 19.2</b>	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх, ашиглах гэх мэт)-ийг ирүүлэх;
<b>ТШЗ 19.3</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “ <b>Шаардана</b> ” Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл ирүүлэх. Хэрвээ гадаадын компани бол уг тусгай зөвшөөрөлтэй дүйцэхүйц баримт бичгийг ирүүлэх.
<b>ТШЗ 21.5</b>	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ <b>Тохируулахгүй тогтмол байна</b> ”
<b>ТШЗ 24.1</b>	Тендерийн баталгааны дүн: Тендерийн баталгааг батлагдсан төсөвт өртгийн 0.5 хувиар тооцож, эх хувиар ирүүлэх. Баталгааны дүн: <b>49,395,520</b> төгрөг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.3-т заасан бусад нөхцөлийг зөвшөөрнө.
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан 16.1-16.4 дэх зүйл заалтуудад тусгагдсан ил болгохыг зөвшөөрсөн баримт бичгийг мэдэгдлийн хамт ирүүлнэ.</p>
<b>ТШЗ 26.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>
<b>ТШЗ 26.2</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 30 минут</b></p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: <b>Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 дугаар хороопол, Нарны зам-62, Юнион бүлдинг, Б блок, 7 давхар.</b></p> <p><b><u>www.tender.gov.mn</u> хаягаар нээнэ.</b></p>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	

<b>ТШЗ 31.1</b>	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “<b>Тийм</b>”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэхдээ: Харьцуулах үнийг харгалзан үнэлнэ.</li> <li>- Мөн хуулийн 11.5-д заасны дагуу бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацааг мөнгөөр илэрхийлэн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж тооцно. Өөрөөр хэлбэл зүтгүүрийг хүлээн авсан өдрөөс эхлэн хамгийн багадаа 55 хоногт, хамгийн ихдээ 75 хоногт багтаан гүйцэтгэх хуваарь ирүүлэхийг зөвшөөрнө. 55-75 хоногийн хоорондох ирүүлсэн хугацааг хоног тутам 0.5 хувиар харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж тооцно. 55 хоногоос дотогш ирүүлсэн хугацааг мөн хувиар харьцуулах үнэ дээр хийсвэрээр хороцуулан тооцно. 75 хоногоос илүү хоцроож гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзана.</li> </ul>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 36.1</b>	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “<b>Тийм</b>”</p> <p>Гүйцэтгэлийн баталгааны дүн: <b>296,373,120</b> /хоёр зуун ерэн зургаан сая гурван зуун далан гурван мянга нэг зуун хорь/ төгрөг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.3-т заасан бусад нөхцөлийг зөвшөөрнө.</p>

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**  
**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ЭЗЭМШЛИЙН БНХАУ-Д**  
**ҮЙЛДВЭРЛЭГДСЭН СКД4в-2301, 2303, 2304, 2305 /ҮЙЛДВЭРИЙН ДУГААР**  
**СКД4в-3001, 3003, 3004, 3005/ ДУГААРТАЙ ГОЛ ЗАМЫН ЗҮТГҮҮРТ ИХ**  
**ЗАСВАРЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

Илчit тэрэгний их засварын ажлыг гүйцэтгэхдээ “Инструкция об эксплуатации и уходе за локомотивом типа СКД4в” Даляльская компания ЛТД по локомотивам и подвижному составу при Китайской Северной корпораций по подвижному составу / Ноябрь2011 г./ “Maihiteahah Mahuaiz CK4b Diesel Electrc Locomotive / Daliah locomotive & Rollihg stock Co. LTD CNR group CHINA/, 316V240ZJD2 дизель хөдөлгүүрийн засвар болон ашиглалтын заавар” / Daliah locomotive & Rollihg stock Co. LTD CNR group CHINA/ дүрэм, заавруудыг баримтлах ба систем, тоноглол, зангилаа эд ангиудыг шалгах, засварлах, шаардлагатайг солих байдлаар гүйцэтгэнэ.

## **1. Дизель хөдөлгүүр**

- 1.1 Дизелийн хөдөлгүүрийн 4 тахир голд бүрэн хэмжилт хийж, тахир голын үндсэн хүзүүний холхивчийн суултыг хэмжиж, үндсэн хүзүүний холхивчийг зохих градацын холхивчоор шинээр солих;
- 1.2 Дизелийн хөдөлгүүрийн тахир голын шатуны хүзүүг хэмжилт хийх ба 64 шатуны холхивчуудыг шинээр солих;
- 1.3 Дизелийн хөдөлгүүрийн 64 ширхэг цилиндрийн втульк шинээр солих;
- 1.4 Дизелийн хөдөлгүүрийн 64 поршень, 256 ширхэг нягтруулах цагиргийн хамт шинээр солих;
- 1.5 Дизелийн хөдөлгүүрийн 64 ширхэг цилиндрийн тагийг бүрэн шалгаж, нягтийг үзэж засварлах;
- 1.6 Цилиндрийн тагны 256 ширхэг сорох болон гаргах клапанг шинээр солих;
- 1.7 Дизелийн хөдөлгүүрийн тахир гол эргүүлэх механизм 4 ширхэг шинээр солих;
- 1.8 Дизелийн хөдөлгүүрийн цилиндрийн тагны индикаторын крануудын ажиллагааг шалгаж засварлах;
- 1.9 Дизелийн хөдөлгүүрийн тахир голын төгсгөлийн тагны жийрэгнүүдийг 4 ширхэг шинээр солих;
- 1.10 Дизелийн хөдөлгүүрийн отсосын шүүр 4 ширхэг шинээр солих;
- 1.11 Дизелийн хөдөлгүүрийн газын коллекторын том жийрэг 32 ширхэг шинээр солих;
- 1.12 Дизелийн хөдөлгүүрийн газын коллекторын дунд жийрэг 64 ширхэг шинээр солих;
- 1.13 Дизелийн хөдөлгүүрийн газын коллекторын жижиг жийрэг 64 ширхэг шинээр солих;
- 1.14 Дизелийн хөдөлгүүрийн 4 тахир голын 4 ширхэг нударган голд бүрэн хэмжилт хийж, үйлдвэр засвараас гарах үеийн хэмжээний шаардлага хангахгүй бол шинээр солих;
- 1.15 Дизелийн хөдөлгүүрийн доргион намжаагч антивибратор 4 ширхэгт их засвар хийх;
- 1.16 Дизелийн хөдөлгүүрийн арын 4 редукторт бүрэн задаргаа хийж их засвар хийх;
- 1.17 Дизелийн хөдөлгүүрийн нэгдсэн эргэлтийн тоо тохируулагчийн доор байрлах тахометр 4 ширхэг шинээр солих;

## **2. Тосны систем**

- 2.1 Тосны системийн уян хоолой 80 ширхэг шинээр бүрэн солих;
- 2.2 Тосны нарийн шүүр 16 ширхэг шинээр бүрэн солих;
- 2.3 Тосны бүдүүн шүүр 16 ширхэг шинээр бүрэн солих;
- 2.4 Тосны 4 туслах насосын бүтээмж шалгаж засварлах;
- 2.5 Тосны насос 8 ширхэг шинээр солих;
- 2.6 Турбокомпрессорын тосны шүүр 8 ширхэг шинээр солих;
- 2.7 Дизелийн хөдөлгүүрийн аюулгүй унтраагч 4 ширхэг шинээр солих;
- 2.8 Дизелийн хөдөлгүүрийн тосны системийн хамгаалах клапан 56 ширхэг шинээр солих;
- 2.9 Дизелийн хөдөлгүүрийн цилиндр хоорондын тосолгооны уян хоолой 56 ширхэг шинээр солих;
- 2.10 Дизелийн хөдөлгүүрийн тосны үндсэн насос 4 ширхэгийг их засвар хийх, шаардлага хангахгүйг шинээр солих;
- 2.11 Тосны нарийн шүүр 8 ширхэг шинээр солих;

### **3.Түлшний систем**

- 3.1 Түлшний өндөр даралтын насос 64 ширхэг шинээр солих;
- 3.2 Түлшний 64 ширхэг форсункны цацууллагч /распытль/ шинээр солих;
- 3.3 Түлшний өндөр даралтын труба 64 ширхэг шинээр солих;
- 3.4 Нэгдсэн эргэлтийн тоо тохируулагч 4 ширхэг шинээр солих;
- 3.5 Түлшний системийн уян хоолой 64 ширхэг шинээр солих;
- 3.6 Түлшний өндөр даралтын секц насос руу орсон уян хоолой 64 ширхэг шинээр солих;
- 3.7 Түлшний өндөр даралтын секц насосоос гарсан уян хоолой 64 ширхэг шинээр солих;
- 3.8 Түлшний 6 шахах насосын бүтээмжийг шалгаж засварлах;
- 3.9 Түлшний бүдүүн шүүр 20 ширхэг шинээр солих;
- 3.10 Түлшний нарийн шүүр 8 ширхэг шинээр солих;
- 3.11 Түлш халаагч 4 ширхэг шинээр солих;
- 3.12 Түлшний даралт тохируулах болон хамгаалах клапан 8 ширхэгийг шинээр солих;
- 3.13 Түлшний 4 ширхэг савыг бүрэн цэвэрлэх;

### **4. Туслах тоноглол**

- 4.1 Компрессор ба түүний цахилгаан моторын холболтын резинэн муфть 192 ширхэг шинээр солих;
- 4.2 Арын хуваарилах редукторын холболтын резинэн муфть 192 ширхэг шинээр солих;
- 4.3 Олсон холбоос 8 ширхэг шинээр солих;
- 4.4 Татах цахилгаан хөдөлгүүрийн 8 ширхэг хөргөх сэнсний их засварлах;
- 4.5 Урд 4 ширхэг редукторт их засвар хийх;
- 4.6 Арын 4 ширхэг редукторт их засвар хийх;
- 4.7 Турбокомпрессорын агаарын резинэн хоолой 8 ширхэг шинээр солих;
- 4.8 Турбокомпрессор 8 ширхэгт их засвар хийх;

### **5. Авто тоормосын систем**

- 5.1 Агаар шахагч компрессор 8 ширхэг их засвар хийх, зүгшрүүлэлт хийж суурилуулах;

- 5.2 Машинчийн кранд /галт тэрэгний/ 8 ширхэг их засвар хийж, стенд дээр турших;
- 5.3 Туслах тоормосын кранд / зүтгүүрийн / 8 ширхэг их засвар хийж стенд дээр турших;
- 5.4 Тоормосын системийн резинэн хоолой 16 ширхэг шинээр солих;
- 5.5 Тоормосын системийн төгсгөлийн кран 32 ширхэг шинээр солих;
- 5.6 Төгсгөлийн 5 төрлийн руков 48 ширхэг шинээр солих;
- 5.7 Тоормосын цилиндрт /48 ширхэг/ бүрэн ревиз хийж резин манжет шинээр бүрэн солих;
- 5.8 Тоормосын цилиндрт агаар дамжуулах резинэн руков 48 ширхэг шинээр солих;
- 5.9 Агаарын 4.5 ат хамгаалах клапан 8 ширхэг шинээр солих;
- 5.10 Агаарын 10.5 ат хамгаалах клапан 8 ширхэг шинээр солих;
- 5.11 Тунадас тургигчийн клапан 8 ширхэг шинээр солих;
- 5.12 Тунадас тунгаагуурт их засвар хийх 4 ширхэг;
- 5.13 Ерөнхий савны тунадас юулэх 8 ширхэг крант шинээр солих;
- 5.14 Тоормосын 48 ширхэг шахавч шинээр солих;
- 5.15 Тоормосын системийн хөшүүргэн дамжлагуудад их засвар хийх;
- 5.16 Тоормосын цилиндрийн шилбэ тохируулах маховик 48 ширхэг шинээр солих;
- 5.17 Таслах крант 64 ширхэг шинээр солих;
- 5.18 Агаар хатаагчийн клапан 8 ширхэг шинээр солих;
- 5.19 Илчit тэрэгний агаар хуваарилагч 4 ширхэг их засвар хийж стенд дээр турших;
- 5.20 Үл буцаах 20 ширхэг клапан шинээр солих;
- 5.21 Ерөнхий сав 8 ширхэг шингэн туршилт хийж баталгаа гаргах;

## **6. Усны систем**

- 6.1 Усны системийн резинэн хоолой 20 ширхэг шинээр солих;
- 6.2 Тэлэх савны усны түвшин мэдрэгч датчик 8 ширхэг шинээр солих;
- 6.3 Усны хаалтуудыг шинээр солих, d40 диаметртэй хаалт 20 ширхэг шинээр солих;
- 6.4 Дөрвөн илчit тэрэгний хөргөлтийн бүх секцүүдийг даралттай усаар стенд дээр шалган их засвар хийх;
- 6.5 Хөргөлтийн 4 ширхэг тэлэх бак шинээр солих;
- 6.6 Тэлэх савны усны түвшин шалгах шилний иж бүрдэл 8 ширхэг шинээр солих;
- 6.7 Тэлэх савны усны дээд талын бүтүүмжийн 4 таг шинээр солих;
- 6.8 Дизель хөдөлгүүрийн хөргөлтийн системийн өндөр, нам температурын 8 ширхэг усны насост их засвар хийх;
- 6.9 Агаар хөргөгч 8 ширхэгийг их засвар хийх;
- 6.10 Тосны дулаан солилцуур 8 ширхэгийг их засвар хийх;
- 6.11 Гидростатикийн дулаан солилцуур 8 ширхэгийг их засвар хийх;

## **7. Хөргөлтийн сэнс**

- 7.1 Ерөнхий сэнсний ан цавыг шалгаж, засварлах;
- 7.2 Өндөр болон нам температурын гидро-насос 8 ширхэг шинээр солих;
- 7.3 Гидро-насосын редуктор 8 ширхэгт их засвар хийх;

## **8. Хөргөлтийн жалюз**

- 8.1 Хөргөлтийн жалюзын цахилгаан хийн винтель 12 ширхэг шинээр солих;
- 8.2 Хөргөлтийн жалюзын далавчны ажиллагааг шалгаж засварлах;

## **9. Дизелийн агаарын систем**

- 9.1 Дизель хөдөлгүүрийн агаарын 4 дамжлагын шүүр 96 ширхэг шинээр солих;

- 9.2 Турбокомпрессорын шүүрийг холбосон агаар дамжуулах хоолой 4 ширхэг шинээр солих;
- 9.3 Мульти циклон 8 ширхэгт их засвар хийх;

## **10. Зай хураагуур**

- 10.1 Зай хураагуур 192 ширхэг шинээр солих;

## **11. Галын тоног төхөөрөмж**

- 11.1 Галын тоног төхөөрөмжинд их засвар хийж, галын 40 ширхэг мэдрэгч шинээр солих;

## **12. Хэмжих хянах хэрэгслүүд**

- 12.1 Тосны даралтын OPSR1, OPRS2, OPRS3, OPRS4 реле 16 ширхэг шинээр солих;
- 12.2 Компрессорын даралт заагч манометр 8 ширхэг шинээр солих;
- 12.3 Гидростатик масло савны температур заагч манометр 8 ширхэг шинээр солих;
- 12.4 Газардуулга шалгах нэмэх, хасах талын гэрэл 8 ширхэг шинээр солих;
- 12.5 Дизель хөдөлгүүрийн өрөөнд байрлах 8 заагчтай хянах самбар дээрх манометр, термометрын иж бүрдэл 4 ширхэг шинээр солих;
- 12.6 Дизель хөдөлгүүрийн өрөөнд байрлах 4 заагчтай хянах самбар дээрх манометр, термометрыг иж бүрдэл 4 ширхэг шинээр солих;
- 12.7 Ерөнхий савны агаарын даралтыг тохируулах даралтын реле 4 ширхэг шинээр солих;
- 12.8 Ерөнхий генераторын /110V/ гүйдэл заагч 8 ширхэг шинээр солих;
- 12.9 Дизель хөдөлгүүрийн эргэлт болон маслын даралт заагч 8 ширхэг шинээр солих;
- 12.10 Машинчийн ширээн дээр байрлах тоормосын манометр 16 ширхэг шинээр солих;
- 12.11 Даралтын электрон мэдрэгч 8 ширхэг шинээр солих;
- 12.12 Температурын электрон мэдрэгч 8 ширхэг шинээр солих;
- 12.13 Татах цахилгаан хөдөлгүүрийн гүйдэл хэмжих шунт эсэргүүцэл 24 ширхэг шалгаж, засварлах;
- 12.14 Батерей цэнэглэлтийн гүйдэл хэмжих шунт эсэргүүцэл 8 ширхэгийг шалгаж засварлах;
- 12.15 Машинчийн пульт дээрх дохиоллын гэрлүүд 16 ширхэг шинээр солих;
- 12.16 Хурд мэдрэгч 4 ширхэг шинээр солих;
- 12.17 Масло, түлшний даралтын манометр, термометр 8 ширхэг холболтын зэс хоолойнуудын уян хоолойг шинээр солих, салдаг штуцертэй болгох;

## **13 Цахилгаан болон элекроникийн зангилаа**

- 13.1 Сэрээлтийн удирдлагын ADLC электрон плат 24 ширхэг шинээр солих;
- 13.2 Дизель хөдөлгүүрийн IFCU электрон плат 4 ширхэг шинээр солих;
- 13.3 ADLC-ын хайрцаг 4 ширхэг шинээр солих;
- 13.4 Хяналтын дэлгэц 8 ширхэг шинээр солих;
- 13.5 Чиг солиурын барабанд их засвар хийх;
- 13.6 Компрессор ажиллуулах контактор 8 ширхэг шинээр солих;
- 13.7 Асаалт явуулах контактор 4 ширхэг шинээр солих;
- 13.8 Сэрээлтийн контактор 4 ширхэг шинээр солих;

- 13.9 Прожекторын гэрэл 8 ширхэг шинээр солих;
- 13.10 Буферын цагаан гэрэл 16 ширхэг шинээр солих;
- 13.11 Буферын улаан гэрэл 16 ширхэг шинээр солих;
- 13.12 Кабины бүдэг гэрэл 16 ширхэг шинээр солих;
- 13.13 Кабины тод гэрэл 32 ширхэг шинээр солих;
- 13.14 Машинч болон туслах машинчийн хөл хэсэгт үлээдэг халаагч 16 ширхэг шинээр солих;
- 13.15 Кабины хөл тень 16 ширхэг шинээр солих;
- 13.16 Хажуу халаагч 16 ширхэг шинээр солих;
- 13.17 Арын халаагч 16 ширхэг шинээр солих;
- 13.18 Өндөр хүчдэлийн камерын 2 талын явах хэсгийн халаагч 8 ширхэг шинээр солих;
- 13.19 Элс, дуун дохионы хөл педаль 24 ширхэг шинээр солих;
- 13.20 Хэт хүчдэлээс хамгаалах YZQ элемент 40 ширхэг шинээр солих;
- 13.21 Элсний болон дуун дохионы цахилгаан хийн винтель 24 ширхэг шинээр солих;
- 13.22 Гар асаалтын үеийн хугацаа баригч реле 4 ширхэг шинээр солих;
- 13.23 Хэт хүчдэлээс хамгаалагч YZQ элемент 12 ширхэг шинээр солих;
- 13.24 Талбай сулруулалтын цахилгаан хийн контакторт их засвар хийж, резинэн өрц 8 ширхэг шинээр солих;
- 13.25 Тоормосын эсэргүүцлийншкафанд байгаа эд ангиудад их засвар хийх;
- 13.26 Тоормосын эсэргүүцлийн хөргөлтийн мотор 4 ширхэгт их засвар хийх;
- 13.27 Тоормосын эсэргүүцлийг шалгаж засварлах;
- 13.28 Реостатын хэвийн ажиллагааг шалгаж, засварлах;
- 13.29 Туслах генераторт /4 ширхэг/ их засвар хийж, стенд дээр турших;
- 13.30 Ерөнхий генераторт /4 ширхэг/ их засвар хийх;
- 13.31 Сэрээгч генераторт /4 ширхэг/ их засвар хийх;
- 13.32 Татах цахилгаан хөдөлгүүрт /24 ширхэг/ их засвар хийх;
- 13.33 Цахилгаан хэлхээний нам болон хүчний хэлхээний залгууруудын найдвартай ажиллагааг шалгаж засварлах;
- 13.34 Дөрвөн зүтгүүрийн өндөр хүчдэлийн өрөөнд байрлах цахилгаан тоноглолын ажиллагааг эрэмбийн дагуу шалгаж засварлах;
- 13.35 Дөрвөн зүтгүүрийн кабин дахь цахилгаан тоноглолын хэвийн ажиллагааг шалгах, засварлах;
- 13.36 Дөрвөн зүтгүүрийн хурдны бичлэгийн төхөөрөмжийг иж бүрэн их засвар хийж, найдвартай ажиллагааг шалгах;
- 13.37 Дөрвөн зүтгүүрийн талбай сулруулалтын эсэргүүцэл, цахилгаан хийн контакторын хэвийн ажиллагааг шалгаж засварлах;
- 13.38 Дөрвөн зүтгүүрийн шулуутгагч диодуудын найдвартай ажиллагааг шалгаж засварлах;
- 13.39 Дөрвөн ерөнхий генераторын 3 фазын шулуутгагч диодуудын найдвартай ажиллагааг шалгаж баталгаажуулах;
- 13.40 Дөрвөн сэрээгч генераторын 3 фазын шулуутгагч диодуудын найдвартай ажиллагааг шалгаж баталгаажуулах;
- 13.41 Дөрвөн зүтгүүрийн Пакетан сэлгэн залгагчуудыг шинээр бүрэн солих;
- 13.42 Өндөр хүчдэлийн цахилгаан хэлхээний тусгаарлалтыг шалгаж засварлах;
- 13.43 Нам хүчдэлийн цахилгаан хэлхээний тусгаарлалтын эсэргүүцлийг шалгаж засварлах;
- 13.44 Ерөнхий генераторын /4 ширхэг/ сэрээлтийн цахилгаан хэлхээний тусгаарлалтын эсэргүүцлийг шалгаж баталгаажуулах;
- 13.45 Дөрвөн зүтгүүрийн өндөр, нам цахилгаан хэлхээ хоорондын тусгаарлалтын эсэргүүцлийг шалгаж засварлах;

13.46 Дөрвөн зүтгүүрийн машинчийн сонор сээрэмж шалгах төхөөрөмжинд их засвар хийж, найдвартай ажиллагааг шалгаж баталгаажуулалт хийх;

#### **14. Цахилгаан явах анги**

14.1 Гүүшингийн 48 холхивчинд их засвар хийж баталгаажуулалт хийх;

14.2 Дөрвөн зүтгүүрийн гүүшингийн рессорын пүрш, хэвтээ татах хөшүүрэг, тэргэнцрийн их биед их засвар хийж баталгаажуулах;

14.4 Дөрвөн зүтгүүрийн хэлбэлзэл намжаагч амортизаторт их засвар хийж хэвийн ажиллагааг шалгах;

14.5 Хос дугуйн /24 ширхэг/ араан дамжлагын редукторт их засвар хийх;

14.6 Тэргэнцрийн резинэн өсгийвчийг шалгаж, засварлах 16 ширхэг;

14.7 Шингээгч аппаратад /8 ширхэг/ их засвар хийх;

14.8 Авто угсраа, авто угсрааны шаантагт /8 ширхэг/ их засвар хийж баталгаажуулалт хийх;

#### **15. Хос дугуй**

15.1 Хос дугуйнд /24 ширхэг/ их засвар хийж баталгаажуулалт хийх;

#### **16. Цахилгаан машинууд**

16.1 Түлшний цахилгаан хөдөлгүүр /8 ширхэг/ их засвар хийх;

16.2 Тосны туслах насост /8 ширхэг/ их засвар хийх;

16.3 Дизель хөдөлгүүрийн өрөөний 8 ширхэг утаа зайлцуулагч цахилгаан хөдөлгүүрт их засвар хийх;

16.4 Компрессорын 8 ширхэг цахилгаан хөдөлгүүрт их засвар хийх;

16.5 Кабины вентиляторын 8 ширхэг цахилгаан хөдөлгүүрт их засвар хийх;

16.6 Нарны хаалтын 8 цахилгаан хөдөлгүүрт их засвар хийх;

16.7 Шил арчигчийн 8 цахилгаан хөдөлгүүрийн их засвар хийх;

16.8 Бохир агаар зайлцуулагчийн 8 ширхэг цахилгаан хөдөлгүүрт их засвар хийх;

#### **17. Аж ахуй**

17.1 Тольны /16 ширхэг/ байдлыг шалгаж засварлах;

17.2 Нарны хаалтын /8 ширхэг/ хэвийн ажиллагааг шалгаж, засварлах;

17.3 Хаалганы /20 ширхэг/ бариулыг засварлаж хэвийн ажиллагааг хангах;

17.4 Хаалганы /20 ширхэг/ резин жийрэг бүрэн хэмжээгээр шинээр солих;

17.5 Шил арчигчид /16 ширхэг/ их засвар хийх;

17.6 Кабины шал 8 ширхэг шинээр солих;

17.7 Кабины онгойдог цонхонд /16 ширхэг/ их засвар хийх;

#### **18. Копут**

18.1 Зүтгүүрийн копутны будгийг сэргээн будах

#### **19. Реостатын туршилт**

19.1 Дөрвөн зүтгүүрийн бүх эд ангиудыг угсарч, төвлөрүүлэлт хийж реостатын бүрэн туршилт хийхэд бүрэн бэлдэх;

19.2 Дөрвөн зүтгүүрт реостатын бүрэн туршилт тохируулгын ажлыг хийх ба энэ ажлыг хийхэд захиалагч талын төлөөллийг оролцуулан хийх;

19.3 Захиалагч талд хүлээлгэн өгөх үеийн товчилсон реостатын туршилт хийж хүлээлгэн өгөх ба явах ангийн зүгшруулэлтийн аялал хийх;

**20. Эд ангиудад тавигдах шаардлага**

20.1. Зүтгүүрт шинээр тавигдах сэлбэг, эд ангиуд нь үйлдвэрлэгдсэнээс хойш 1 жилээс ихгүй хугацаагаар хадгалагдсан, шинэ байх;

20.2. Зүтгүүрт шинээр тавигдах сэлбэг, эд ангиудын баталгаат хугацаа 1 жилээс багагүй байх;

**21. Тээвэрлэлт**

21.1. Зүтгүүр засварлагдах газар руу очих, ирэх тээвэрлэлтийн зардлыг хариуцна.

#### **IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

##### **1. Үйлчилгээ дуусгах хугацаа: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]**

Хэрэв “ашиглах” бол: *Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.*

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**—аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү [**“cap”, “өдөр” гэдэг үнээс сонгож бичих**] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

##### **2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]**

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

##### **3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]**

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

##### **4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]**

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]**

